

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 сарын 30-ны өдөр

№ 21

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.20 дахь заалт, Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн нэгдмэл сонирхол бүхий хуулийн этгээд болох “Гялс төгрөг” ХЗХ-ны татан буулгасан 20-н салбарт ашиглагдаж байсан энэхүү тогтоолын Хавсралт 1-д заасан эд хөрөнгийг тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй “Сэндли ББСБ” ХК-ийн салбарт баланст бүртгэлтэй үнийг бууруулан харилцан тохиролцсон үнээр худалдан авах буюу эд хөрөнгө худалдах, худалдан авах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү шийдвэрийн 1-д дурдсан сонирхлын зөрчилтэй хэлцэлд компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Одгэрэл-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

